



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны Өвөрхангай, Увс аймаг дахь салбарын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2017 оны 20/429, 2018 оны 15/07/025/67 дугаар дүгнэлтээр ашиглах боломжгүй нь тогтоогдсон нийт 294,927,686.58 (хоёр зуун ерэн дөрвөн сая есөн зуун хорин долоон мянга зургаан зуун наян зургаан төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 63,069,740.28 (жаран гурван сая жаран есөн мянга долоон зуун дөчин төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 2 ширхэг барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Төрийн банкны гүйцэтгэх захирал Г.Дөлгөөнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

2.4.Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0000861



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн  
 269 дугаар тогтоолын хавсралт

Төрийн банкны Өвөрхангай, Увс аймаг дахь салбарын үндсэн  
 хөрөнгөд бүртгэлтэй актлах барилгын жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Өвөрхангай аймаг дахь Төрийн банкны салбарын конторын барилга	2005	Өвөрхангай, Арвайхээр сум, 3 дугаар баг, блокон ханатай, модон бамбай хучилттай, 2 давхар, 15,0*10,0м	139,757,256.58	35,113,549.97	104,643,706.61
2	Увс аймаг дахь Төрийн банкны салбарын конторын барилга	1963	Увс, Улаангом сум, 2 дугаар баг, чулуун суурьтай, түүхий тоосгон ханатай, модон хучилттай, 1 давхар, 198м2	155,170,430.00	27,956,190.31	127,214,239.69
Нийт дүн				294,927,686.58 (хоёр зуун ерэн дөрвөн сая есөн зуун хорин долоон мянга зургаан зуун наян зургаан төгрөг тавин найман мөнгө)	63,069,740.28 (жаран гурван сая жаран есөн мянга долоон зуун дөчин төгрөг хорин найман мөнгө)	231,857,946.30 (хоёр зуун гучин нэгэн сая найман зуун тавин долоон мянга есөн зуун дөчин дөчин зургаан төгрөг гучин мөнгө)